



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2023/64-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2023 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Ахлах аудитор Н.Алтантуяа Утас: 7033-3019 Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 65130 Цэцэрлэг, Архангай аймаг Утас/Факс:976-70333141 И-мэйл: arkhangai@audit.gov.mn	АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.АЛТАНГЭРЭЛ ТАНАА
2023.04.05 № 130	
танай _____-ны № _____-т	
Хязгаарлалттай дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Архангай аймгийн ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p>	
Дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none">• Аймгийн засаг даргын нөөц хөрөнгөөс аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн урьдчилан төлөвлөж, төсөвт тусган батлуулах боломжтой 117,360,000 төгрөгийн төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн, "Архангай орон сууц корпорац" орон нутгийн өмчит ХХК-ийг орлого төвлөрүүлэх, үр ашигтай ажиллуулах арга хэмжээ авч ажиллалгүйгээр урсгал зардлыг засаг даргын нөөц хөрөнгөөс 33,500,000 төгрөгөөр санхүүжүүлсэн, Засаг дарга нь тайлант онд 2 зөвлөх, орлогчийг ажиллуулж нийт 24,052,942 төгрөгийн цалингийн зардал гаргаж төсвийн хөрөнгийг хэмнэлтгүй зарцуулсан. <p>Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмыг зөрчсөн, бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс дээгүүр байгаа ба аудитын тохиолдсон байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.</p>	
Асуудлыг онцолсон хэсэг	
<p>"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан "Стандарттай Архангай" арга хэмжээний хүрээнд аймгийн Засаг даргын тамгын газар болон төрийн байгууллагуудад Чанарын удирдлагын тогтолцоо (ISO-9001:2015)-г нэвтрүүлнэ" гэсэн зорилтын хүрээнд Архангай аймгийн ЗДТГ газар нь 2022 онд Чанарын менежментийн тогтолцооны ISO стандартыг нэвтрүүлж эхэлсэн байна.</p>	

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 43 зорилт, 102 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргаас 91.2 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	45,190,748.00	66,133,848.00
35	БАРАА МАТЕРИАЛ	45,190,748.00	66,133,848.00
35400	Хангамжийн материал	45,190,748.00	66,133,848.00
35410	Бичиг хэргийн материал	6,240,750.00	26,794,600.00
35420	Аж ахуйн материал	14,517,858.00	17,526,698.00
35430	Сэлбэг хэрэгсэл	6,457,200.00	2,217,200.00
35440	Түлш, шатах тослох материал	62,440.00	1,682,850.00
35450	Барилгын засварын материал	45,000.00	45,000.00
35470	Бусад хангамжийн материал	17,867,500.00	17,867,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,646,838,730.99	3,586,033,680.59
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,646,838,730.99	3,586,033,680.59
39200	Биет хөрөнгө	3,163,903,730.99	3,114,238,680.59
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,988,281,068.08	2,988,281,068.08
39202	Хуримтлагдсан элэгдэл	-156,766,455.84	-208,926,798.24
39203	Авто-тээврийн хэрэгсэл	455,830,000.00	372,080,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-403,589,444.42	-355,791,666.68
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	421,978,756.65	351,635,225.37
39206	Хуримтлагдсан элэгдэл	-230,448,683.01	-151,774,596.66
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	206,891,330.42	219,714,778.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-139,978,535.28	-137,005,856.92
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	23,900,000.00	27,250,000.00
39212	Хуримтлагдсан элэгдэл	-2,194,305.61	-6,031,805.68
39214	Бусад үндсэн хөрөнгө	53,500,000.00	15,700,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-53,500,000.00	-891,666.68
39300	Биет бус хөрөнгө	482,935,000.00	471,795,000.00
39301	Програм хангамж	2,980,000.00	900,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,755,000.00	-855,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	512,710,000.00	471,750,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-30,000,000.00	0.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,692,029,478.99	3,652,167,528.59
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,692,029,478.99	3,652,167,528.59
51	Засгийн газрын хувь оролцоо	3,692,029,478.99	3,652,167,528.59
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,223,981,214.28	2,223,981,214.28
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,223,981,214.28	2,223,981,214.28
51200	Хуримтлагдсан үр дүн	-822,769,429.51	-862,608,327.91
51210	Өмнөх үеийн үр дүн	1,182,725,250.71	-822,746,377.51
51220	Тайлант үеийн үр дүн	359,955,821.20	-39,861,950.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,290,817,694.22	2,290,794,642.22
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,692,029,478.99	3,652,167,528.59

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,626,205,152.21	4,014,158,373.37
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	522,231,933.21	115,866,985.37
120	Нийтлэг татварын бус орлого	519,546,633.21	115,866,985.37
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	426,805,900.00	13,821,750.00

Архангай аймгийн ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,815,900.00	13,821,750.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	405,990,000.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	88,740,733.21	102,045,235.37
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	4,000,000.00	0.00
122	Тусламжийн орлого	2,685,300.00	0.00
122001	Хандив тусламж /дотоод/	2,685,300.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,103,973,219.00	3,898,291,388.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	891,712,619.00	851,551,988.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	414,082,847.00	500,429,936.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	477,629,772.00	351,122,052.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	3,212,260,600.00	3,046,739,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,212,260,600.00	3,046,739,400.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,266,249,331.01	4,043,060,323.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,266,249,331.01	4,043,060,323.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,542,924,269.46	3,873,485,606.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	945,497,138.69	1,024,372,659.00
210101	Үндсэн цалин	533,564,910.17	682,832,435.00
210102	Нэмэгдэл	346,532,555.00	207,765,325.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,893,871.52	74,040,300.00
210104	Урамшуулал	0.00	43,333,906.00
210105	Гэрээт ажлын хөлс	12,505,802.00	16,400,693.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,544,016.76	123,348,214.75
210201	Тэтгэврийн даатгал	84,927,012.50	86,643,110.59
210202	Тэтгэмжийн даатгал	8,483,487.22	9,027,455.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,355,379.50	7,108,859.49
210204	Ажилгүйдлийн даатгал	1,383,266.84	1,873,843.89
210205	Эрүүл мэндийн даатгал	14,394,870.70	18,694,945.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	233,384,092.00	236,443,992.00
210301	Гэрэл, цахилгаан	9,899,348.00	10,458,063.00
210302	Түлш, халаалт	219,893,520.00	219,893,520.00
210303	Цэвэр, бохир ус	3,591,224.00	6,092,409.00
2104	Хангамж, бараа материалын зардал	108,971,393.00	99,197,769.00
210401	Бичиг хэрэг	30,807,580.00	25,372,700.00
210402	Тээвэр, шатахуун	35,397,171.00	38,211,978.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,862,053.00	16,178,389.00
210404	Ном, хэвлэл	3,005,200.00	2,640,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,833,650.00	2,089,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,065,739.00	14,705,702.00
2105	Нормативт зардал	1,440,000.00	3,551,000.00
210502	Хоол, хүнс	0.00	1,398,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,440,000.00	2,153,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	61,360,495.00	44,270,080.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,502,100.00	1,097,400.00
210604	Урсгал засвар	59,858,395.00	43,172,680.00
2107	Томилолт, зочны зардал	20,482,000.00	26,065,800.00
210702	Дотоод албан томилолт	20,482,000.00	26,065,800.00

Архангай аймгийн ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	274,561,745.00	14,165,716.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	261,796,149.00	7,928,902.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,455,490.00	1,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	387,066.00	333,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,585,000.00	1,704,000.00
210807	Газрын төлбөр	2,717,040.00	2,578,514.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,782,683,389.01	2,302,070,375.77
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,602,084,267.00	2,067,728,890.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,576,000.00	52,404,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	174,023,122.01	181,937,285.77
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	723,325,061.55	169,574,717.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,053,480.00	92,211,106.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,570,200.00	16,511,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,783,800.00	35,395,291.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	43,699,480.00	40,304,015.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	670,271,581.55	77,363,611.25
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	487,566,529.83	74,720,390.25
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	182,705,051.72	2,643,221.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	359,955,821.20	-28,901,950.40
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	10,960,000.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	10,960,000.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	359,955,821.20	-39,861,950.40

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,124,789,119.00	3,912,113,138.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,815,900.00	13,821,750.00
120	Нийтлэг татварын бус орлого	20,815,900.00	13,821,750.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,815,900.00	13,821,750.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,815,900.00	13,821,750.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,103,973,219.00	3,898,291,388.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	891,712,619.00	851,551,988.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	414,082,847.00	500,429,936.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	477,629,772.00	351,122,052.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	3,212,260,600.00	3,046,739,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,212,260,600.00	3,046,739,400.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,090,409,119.00	3,882,066,138.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,090,409,119.00	3,882,066,138.00

**Архангай аймгийн ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан**

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,367,084,057.45	3,712,491,420.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	945,497,138.69	1,024,372,659.00
210101	Үндсэн цалин	569,368,474.71	699,349,604.64
210102	Нэмэгдэл	311,573,707.46	199,499,250.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	48,399,797.00	66,189,205.81
210104	Урамшуулал	0.00	42,933,905.55
210105	Гэрээт ажлын хөлс	16,155,159.52	16,400,693.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,544,016.76	123,348,214.75
210201	Тэтгэврийн даатгал	78,556,096.77	84,755,526.73
210202	Тэтгэмжийн даатгал	8,760,278.02	9,537,991.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,981,341.17	7,074,066.79
210204	Ажилгүйдлийн даатгал	1,692,144.16	2,255,008.36
210205	Эрүүл мэндийн даатгал	18,554,156.64	19,725,621.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	233,384,092.00	236,443,992.00
210301	Гэрэл, цахилгаан	9,899,348.00	10,458,063.00
210302	Түлш, халаалт	219,893,520.00	219,893,520.00
210303	Цэвэр, бохир ус	3,591,224.00	6,092,409.00
2104	Хангамж, бараа материалын зардал	98,619,883.00	96,618,469.00
210401	Бичиг хэрэг	22,381,800.00	20,661,200.00
210402	Тээвэр, шатахуун	35,266,600.00	39,832,388.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,428,093.00	16,178,389.00
210404	Ном, хэвлэл	4,334,200.00	2,640,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,600,000.00	2,089,992.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,609,190.00	15,216,500.00
2105	Нормативт зардал	1,440,000.00	3,551,000.00
210502	Хоол, хүнс	0.00	1,398,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,440,000.00	2,153,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	64,696,125.00	42,739,880.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,720,000.00	3,767,000.00
210604	Урсгал засвар	58,976,125.00	38,972,880.00
2107	Томилолт, зочны зардал	20,482,000.00	26,065,800.00
210702	Дотоод албан томилолт	20,482,000.00	26,065,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	273,956,745.00	14,165,716.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	261,853,123.00	7,928,902.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,455,490.00	1,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	330,092.00	333,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,980,000.00	1,704,000.00
210807	Газрын төлбөр	2,717,040.00	2,578,514.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,614,464,057.00	2,145,185,690.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,607,888,057.00	2,092,781,490.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,576,000.00	52,404,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	723,325,061.55	169,574,717.25
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,053,480.00	92,211,106.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,570,200.00	16,511,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,783,800.00	35,395,291.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	43,699,480.00	40,304,015.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	670,271,581.55	77,363,611.25
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	487,566,529.83	74,720,390.25
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	182,705,051.72	2,643,221.00

Архангай аймгийн ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	34,380,000.00	30,047,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	34,380,000.00	30,047,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	34,380,000.00	30,047,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	34,380,000.00	30,047,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	34,380,000.00	30,047,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-34,380,000.00	-30,047,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,223,981,214.28	2,290,817,694.22	- 1,182,725,250.71	3,332,073,657.79
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,223,981,214.28	2,290,817,694.22	- 1,182,725,250.71	3,332,073,657.79
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	359,955,821.20	359,955,821.20
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,223,981,214.28	2,290,817,694.22	-822,769,429.51	3,692,029,478.99
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,223,981,214.28	2,290,817,694.22	-822,769,429.51	3,692,029,478.99
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	23,052.00	23,052.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,223,981,214.28	2,290,817,694.22	-822,746,377.51	3,692,052,530.99
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-23,052.00	0.00	-23,052.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-39,861,950.40	-39,861,950.40
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,223,981,214.28	2,290,794,642.22	-862,608,327.91	3,652,167,528.59

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Харьцуулалт
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,787,956,400.00	2,985,840,759.75	802,115,640.25	78.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,672,321,800.00	2,985,840,759.75	686,481,040.25	81.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,580,084,800.00	2,893,629,653.75	686,455,146.25	80.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,041,974,300.00	1,007,971,966.00	34,002,334.00	96.74
210101	Үндсэн цалин	668,550,000.00	699,349,604.64	-30,799,604.64	104.61
210102	Нэмэгдэл	237,020,000.00	199,499,250.00	37,520,750.00	84.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	86,754,300.00	66,189,205.81	20,565,094.19	76.30
210104	Урамшуулал	49,650,000.00	42,933,905.55	6,716,094.45	86.47
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	130,247,100.00	121,298,175.75	8,948,924.25	93.13
210201	Тэтгэврийн даатгал	88,568,100.00	83,038,609.92	5,529,490.08	93.76
210202	Тэтгэмжийн даатгал	10,419,700.00	9,454,710.91	964,989.09	90.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,335,700.00	7,007,442.36	1,328,257.64	84.07
210204	Ажилгүйдлийн даатгал	2,084,100.00	2,238,352.25	-154,252.25	107.40
210205	Эрүүл мэндийн даатгал	20,839,500.00	19,559,060.31	1,280,439.69	93.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	237,848,900.00	236,443,992.00	1,404,908.00	99.41
210301	Гэрэл, цахилгаан	11,859,000.00	10,458,063.00	1,400,937.00	88.19
210302	Түлш, халаалт	219,894,900.00	219,893,520.00	1,380.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	6,095,000.00	6,092,409.00	2,591.00	99.96
2104	Хангамж, бараа материалын зардал	92,735,600.00	91,798,649.00	936,951.00	98.99
210401	Бичиг хэрэг	18,673,800.00	18,673,800.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	37,000,000.00	36,999,968.00	32.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,205,300.00	16,178,389.00	26,911.00	99.83
210404	Ном, хэвлэл	2,640,000.00	2,640,000.00	0.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,000,000.00	2,089,992.00	910,008.00	69.67
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,216,500.00	15,216,500.00	0.00	100.00
2105	Нормативт зардал	4,200,000.00	3,551,000.00	649,000.00	84.55
210502	Хоол, хүнс	1,400,000.00	1,398,000.00	2,000.00	99.86
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,800,000.00	2,153,000.00	647,000.00	76.89
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	41,857,500.00	41,797,805.00	59,695.00	99.86
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,500,000.00	12,465,800.00	34,200.00	99.73
210604	Урсгал засвар	29,357,500.00	29,332,005.00	25,495.00	99.91
2107	Томилолт, зочны зардал	28,986,500.00	24,475,800.00	4,510,700.00	84.44
210702	Дотоод албан томилолт	28,986,500.00	24,475,800.00	4,510,700.00	84.44
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,261,800.00	14,165,716.00	1,096,084.00	92.82
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,946,800.00	7,928,902.00	17,898.00	99.77
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00		500,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	333,300.00	333,300.00	0.00	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	191,700.00	121,000.00	70,700.00	63.12

Архангай аймгийн ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,750,000.00	1,704,000.00	46,000.00	97.37
210807	Газрын төлбөр	3,040,000.00	2,578,514.00	461,486.00	84.82
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,986,973,100.00	1,352,126,550.00	634,846,550.00	68.05
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,984,173,100.00	1,349,826,550.00	634,346,550.00	68.03
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,800,000.00	2,300,000.00	500,000.00	82.14
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	92,237,000.00	92,211,106.00	25,894.00	99.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	92,237,000.00	92,211,106.00	25,894.00	99.97
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,511,800.00	16,511,800.00	0.00	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	35,415,800.00	35,395,291.00	20,509.00	99.94
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	40,309,400.00	40,304,015.00	5,385.00	99.99
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	115,634,600.00		115,634,600.00	0.00
223001	Бусад хөрөнгө	115,634,600.00		115,634,600.00	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,787,956,400.00	2,985,840,759.75	802,115,640.25	78.82
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,775,956,400.00	2,972,019,009.75	803,937,390.25	78.71
320001	Орон нутгийн төсвөөс	3,775,956,400.00	2,972,019,009.75	803,937,390.25	78.71
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	12,000,000.00	13,821,750.00	-1,821,750.00	115.18
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,000,000.00	13,821,750.00	-1,821,750.00	115.18
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	129.00	137.00	-8.00	106.20
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	64.00	68.00	-4.00	106.25
620001	Удирдах ажилтан	13.00	11.00	2.00	84.62
620002	Гүйцэтгэх ажилтан	30.00	34.00	-4.00	113.33
620003	Үйлчлэх ажилтан	19.00	21.00	-2.00	110.53
620004	Гэрээт ажилтан	2.00	2.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	851,551,988.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	833,553,788.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	830,910,567.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,400,693.00
210105	Гэрээт ажлын хөлс	16,400,693.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,050,039.00
210201	Тэтгэврийн даатгал	1,716,916.81
210202	Тэтгэмжийн даатгал	83,280.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	66,624.43
210204	Ажилгүйдлийн даатгал	16,656.11
210205	Эрүүл мэндийн даатгал	166,561.10
2104	Хангамж, бараа материалын зардал	4,819,820.00
210401	Бичиг хэрэг	1,987,400.00
210402	Тээвэр, шатахуун	2,832,420.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,640,875.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,640,875.00
2107	Томилолт, зочны зардал	1,590,000.00
210702	Дотоод албан томилолт	1,590,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	796,409,140.00

Архангай аймгийн ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	746,304,940.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	50,104,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,643,221.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,643,221.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	2,643,221.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,998,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	17,998,200.00
222001	Тоног төхөөрөмж	17,998,200.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	851,551,988.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	500,429,936.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	351,122,052.00

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймгийн ЗДТГ нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 175 мэдээллийг 171 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.1.1-д “Тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ... жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор, 6.4.8-д”... төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”-ийг 7 хоногийн дотор мэдээлнэ гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 814.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрч санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ. Үүнд: 814.0 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж худалдаж авсныг мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус хөрөнгө худалдан авснаар тайлагнаагүй байсныг залруулав.

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг аймгийн ЗДТГ-ын дарга Ц.Бадрахад хүргүүлэхэд асуудлын бүртгэлд 2023 оны 03 дугаар сарын 07-ны 03/391 тоот албан бичгээр хариу тайлбар ирүүлсэн. Тус тайлбарыг үнэлж, холбогдох албан тушаалтнуудаас тайлбар тодруулга авч, Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн өргөтгөсөн хурлаар хэлэлцэн авч үзээд дараах шийдвэрүүдийг гаргалаа.

Аудитаар залруулагдаагүй нийт 181,725.3 мянган төгрөгийн зөрчил² илэрч, 7 албан шаардлага хүргүүллээ.

3.1 Албан шаардлага

5.1.1 Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Б/34, Б/35 дугаар тушаалаар Г.Алтан-Очирыг байгаль орчин, хог хаягдлын менежмент хариуцсан зөвлөхөөр, Д.Бат-Эрдэнийг боловсрол, нийгмийн асуудал хариуцсан ахлах зөвлөхөөр тус тус томилон ажиллуулж, 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Б/144, Б/145 дугаар тушаалаар ажлаас чөлөөлж, дээрх хугацаанд нийт 19,712.1 мянган төгрөгийн цалин хөлс олгосон байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т “Засгийн газрын агентлагийн дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны этгээд ажиллуулахыг хориглоно”, 5.4-т “Энэ хуульд заасныг зөрчиж ...зөвлөхийн чиг үүрэгтэй ижил эрх, үүрэг бүхий өөр нэршилтэй албан тушаалын орон тоо бий болгох, түүнд аливаа албан тушаалтныг томилох, орон тоог хэвээр хадгалахыг хориглоно”, 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.2-т “Чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох” гэж заасантай нийцэхгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3.1.2 Аймгийн Засаг дарга нь хоёр орлогч даргатай ажиллаж байсан бөгөөд 2022 оны 01 дүгээр сарны 03-ны өдрийн Б/01 дүгээр захирамжаар П.Бат-Эрдэнийг Засаг даргын орлогчоор томилон ажиллуулж, 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн Б/32 дугаар захирамжаар түүнийг ажлаас нь чөлөөлсөн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 -т "Нийслэлийн Засаг дарга хоёр, аймаг, дүүрэг, сумын Засаг дарга нэгээс илүү орлогч даргатай байхыг хориглоно", Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн "Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж зарим арга хэмжээний тухай" 203 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.1-т "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1, 5.2-т заасны дагуу тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглосон төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтныг ажлаас чөлөөлөх арга хэмжээ авч, тэтгэмжийг зохих журмын дагуу шийдвэрлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3.1.3. Аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/52 дугаар захирамжаар удирдлагын академийн ахлах түшмэлийн захиалгат сургалтад "Архангай орон сууц корпораци"-ийн захирал М.Гүрсүрэн, иргэн С.Баатархуяг нарыг хамруулж засаг даргын нөөц хөрөнгөөс 3,240.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийн үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 11 дүгээр сарын 05-ний өдрийн 04 дүгээр зөвлөмжийн 11-д "Төрийн жинхэнэ албаны нөөцөд төрийн албаны албан тушаал эрхлээгүй иргэдийн хувьд Төрийн албаны тухай хуулийн тусгай шаардлагыг бүрэн хангасан тохиолдолд Төрийн албаны зөвлөлөөс албан тушаалын аль нөөцийн шаардлагыг хангаж байгаа тухай тодорхойлолт гаргуулсны үндсэн дээр хувиараа төлбөрөө төлж зохих ангиллын мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах боломжтой байхаар зохион байгуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3.1.4 Аймгийн засаг даргын нөөц хөрөнгөөс "Архангай аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгчдийг ЭЕШ-д бэлтгэх төсөл"-ийг хэрэгжүүлэхээр тендер зарлаж, тендерт шалгарсан "Феликс нэтворк" ХХК-тай 117,360.0 мянган төгрөгөөр гэрээ байгуулан ажилласан байна. Тус төслийн цар хүрээ, зарцуулсан хөрөнгөөс үзэхэд аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн урьдчилан төлөвлөж, төсөвт тусган батлуулах боломжтой төсөл арга хэмжээ байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийн үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.1-д "Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад хуулиар олгогдсон бүрэн эрхтэй зөрчилдөхгүй, урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсны улмаас тухайн төсвийн жилийн дундуур зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ, зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэх, гүйцэтгэлийг тайлагнахад энэ журмыг мөрдөнө" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3.1.5 Тайлант онд "Архангай орон сууц корпораци" орон нутгийн өмчит ХХК-ийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 12 дугаар тогтоолоор байгуулсан бөгөөд аймгийн засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/109 дүгээр захирамжаар "Архангай орон сууц корпораци" орон нутгийн өмчит ХХК-ний үйл

ажиллагаанд 33,500.0 мянган төгрөгийн дэмжлэг олгосон байна. "Архангай орон сууц корпораци" орон нутгийн өмчит ХХК нь өөрийн орлого төвлөрүүлээгүй, ашиггүй ажилласан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-д "Зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 15 дугаар зүйлийн 15.2.6-д "Байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийн үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3.1.6 Тайлант онд аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан тушаалын сул орон тоог нөхөхөөр төрийн албаны холбогдох шатны байгууллагад сонгон шалгаруулалт явуулах захиалгыг хүргүүлээгүй байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-т "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан тушаалд энэ хуулиар тогтоосон шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнийг сонгон шалгаруулж томилно", 26.1-т "Төрийн захиргааны албан тушаалд энэ хуулийн 3.1.3-т заасан чадахуйн зарчмыг үндсэн шалгуур болгож, түүнийг хамгийн сайн хангасан хүнийг томилно", 27.2-т "Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3.1.7 Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн "Архангай аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай" А/16 дугаар тушаалаар Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн орон тоонд *төрийн үйлчилгээ-мэдээллийн төв хариуцсан ажилтны* орон тоог баталсан бөгөөд 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн Б/30 дугаар тушаалаар Г.Гэрэлмааг тус орон тоонд томилон ажиллуулж нийт 7,913.2 мянган төгрөгийг олгосон байна. Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн төрийн үйлчилгээ-мэдээллийн төв хариуцсан ажилтны гүйцэтгэх ажил үүргийг албан тушаалын тодорхойлолтоор тодорхой батлаагүй бөгөөд Г.Гэрэлмаа нь тус албан тушаалын ажлыг хийж гүйцэтгээгүй, харин үйлчлэгчийн ажлыг хийж байна. ЗДТГ-ын дарга нь 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн "Бүтэц, орон тоо батлах тухай" А/13 дугаар тушаалаар нийтлэг үйлчилгээний газрын бүтэц, орон тоог батлахдаа нийтлэг үйлчилгээний газрын орон тоонд *төрийн үйлчилгээ-мэдээллийн төв хариуцсан ажилтны* орон тоог давхардуулан баталсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.2-т "Чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох", Орон нутгийн 2022 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамжийн 2.1.2-т "Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Аймгийн ЗДТГ	1	814.0	0	0	1	814.0	1	814.0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Аймгийн ЗДТГ	7	181725.3	0	0	7	181725.3	0	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил			
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Аймгийн ЗДТГ	1	0	0	0	0	0	1	0	0	0	0	0